

ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ЗАЙНЫ ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.05.20

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “ИНЕГ-ын харьяа орон нутаг дахь Нисэх буудлуудын үйл ажиллагаанд зайны дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 21/06 тоот удирдамжийн хүрээнд Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Нисэх буудлын үйл ажиллагаанд 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийг хүртэлх хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын Дотоод аудитын албаны санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа дотоод аудит, хяналт шалгалтыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Завхан аймаг дахь Тосонцэнгэл нисэх буудлын 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, нисэх буудлын даргын гаргасан тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, худалдан авалт, цалин хөлсний бодолт, олголт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Нисэх буудлын 18 ажилтны албан тушаалын тодорхойлолтод тавигдсан шаардлагуудыг тулган үзэхэд 3 ажилтан албан тушаалын тодорхойлолтод тавигдсан зарим шаардлагыг хангаагүй байна.

Тосонцэнгэл сум дахь нисэх буудал нь ажилтны тухайн сард хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл, үр дүн, ажлын цаг ашиглалт, сахилга хариуцлага, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, байгууллагаас зохион байгуулж байгаа олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдлаар нь дүгнэж, олгох хувь, хэмжээг бүрэн гүйцэд дүгнэхгүй байгаагаас тухайн ажилтан ямар ажлыг хийж гүйцэтгээгүйгээс үр дүнгээсээ хэдэн хувь хасуулсан нь тодорхойгүй байна.

Ажилтнуудад ажилтны цагийн бүртгэлийг үндэслэн хүйтний нэмэгдлийг олгох ёстой байтал гадаа хүйтэн нөхцөлд ажиллаагүй байхад үндсэн цалингийн 10 хувиар тооцож хүйтний нэмэгдлийг олгосон байна.

ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 6.5.9-д ...Орон сууцны дэмжлэгт хамрагдсан ажилтныг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй орон сууцанд амьдруулахыг хориглоно... гэж заасныг зөрчсөн байна.

ХАБЭА-н зөвлөлөөс холбогдох сургалтыг зохион байгуулж идэвх гарган ажиллаж байгаа хэдий ч сургалтын үр дүнтэй байдал, ажилтнуудад мэдлэг олгосон нотолгоог бүрдүүлэх, шалгалт авах ажлыг орхигдуулсан байна.

Өмнөх дотоод аудитаар өгсөн Шилэн дансны мэдээлэл байршуулах тухай зөвлөмжийн хэрэгжилт 2020 онд хангалтгүй буюу зөрчил давтан гарсаар байсан байна. Харин 2021 оны 01 дүгээр улирлын байдлаар шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв сайн мэдээлж байна.

ИНЕГ-ын даргын баталсан 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн ИНЕГ-ын харьяа орон нутаг дахь Нисэх буудлуудын үйл ажиллагаанд зайны дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 20/06 тоот удирдамжийн хүрээнд хийгдсэн дотоод аудитаар өгөгдсөн зөвлөмжийн

хэрэгжилт 82 хувийн хэрэгжилттэй байгаа ба бүрэн хэрэгжээгүй ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг засаж, залруулах талаар тус нисэх буудалд 5 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА